

**ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТЭДГЭЭРИЙГ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁОГ**

д/д	Ирүүлсэн санал	Тусгасан байдал, тайлбар
<b>I.Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо</b>		
1.	Холбоо даатгагчтай нэгдмэл сонирхолтой хохирогчид нөхөн төлбөр олгох асуудал буруу, иймд хөндлөнгийн хараат бус этгээд болох хохирол үнэлэгчийг оролцуулах	Үгүй. Даатгагчийн үйлчилгээний нэг хэсэг бөгөөд үнэ эхний удаад даатгагчийн томилсон хохирол үнэлэгч үнэ төлбөргүй үнэлэх ба даатгуулагч эсхүл хохирогч өөрөө хүсэлт гаргах, мөн тус даатгалын үнэлгээтэй санал нийлэхгүй байх тохиолдолд хөндлөнгийн хохирол үнэлгээчнээр дахин үнэлгээ хийлгэх боломжтойгоор тусгав.
2.	Хохирол үнэлэх технологийг ашигласан үнэлгээний тодорхойлолтыг даатгагч хариуцан хэрэгжүүлэх тул Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хараат бус шударга байх зарчимд нийцэхгүй мөн үнэлгээчнийг сонгох үйлчлүүлэгчийн эрхийг зөрчихөөр байна.	Үгүй. Даатгагчийн орон тооны ажилтан нь холбогдох сургалтад хамрагдсан байх бөгөөд шууд технологи ашиглан үнэлгээ хийнэ гэдэг өрөөсгөл. Мөн олон улсын жишгээр хөрөнгийн үнэлгээ, хохирол үнэлгээ 2-ын ойлголтыг тусад нь авч үзэх нь зүйтэй байна.
3.	Холбооны нөхөн төлбөр олгох, тогтооход оролцдог байдлыг хасаж Даатгалын тухай хуулийн төсөлд Даатгалын мэргэжлийн оролцогч байгууллага хэлбэрээр эрх зүйн байдлыг тодорхойлж буй нөхцөлд хараат бус этгээд болох даатгалын хөндлөнгийн хохирол үнэлэгчийг оролцуулах шаардлагатай.	Тийм. Хуулийн төслийн дагуу даатгалын хөндлөнгийн хохирол үнэлэгчээр үнэлгээ хийлгэх сонголттойгоор тусгасан болно.
<b>II.Монгол даатгал ХК</b>		
1	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1.1 дэх хэсгийг өөрчлөх. Уг заалтын “автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс” гэснийг “автотээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнөөс” гэж өөрчлөх.	Тийм. Хуулийн төсөлд “Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс” гэдгийг хасаж “зам, тээврийн ослын болон авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас” гэж өөрчлөн найруулав.
2.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 3.1.9 дэх заалтыг хасах. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Заавал даатгалын холбооны эрх зүйн байдлыг зохицуулж өгсөн бөгөөд энэ холбоо жолоочийн заавал даатгалд хамрагдаагүй этгээд, гэрээний хугацаа	Үгүй. Хуулийн төсөлд заавал даатгалын сан нь зөвхөн баталгаат сангийн үүргийг гүйцэтгэх буюу дампуурсан даатгагчийн хохирогч нарын хохирлыг барагдуулах зорилготой. Харин хохирогчийн эрхийг хамгаалах нэгдсэн бүтэц нь

	<p>дууссан мөн даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй этгээдийн хохирлыг Хохирогчийн эрхийг хамгаалах холбоо бус Заавал даатгалын холбоо нь барагдуулаад тухай этгээдээс буцаан нэхэмжлэх зохицуулалт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Иймд Хохирогчийн эрх хамгаалах холбоо гэж хуулийн этгээдийг тусад нь байгуулах шаардлагагүй байна.</p>	<p>даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй, даатгалгүй этгээдийн хохирлыг барагдуулахаар тусгасан болно. Мөн хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд “Тус хуулийн зорилт нь ... хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог бөгөөд тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах, хохирогчид нөхөн төлбөр олгох, жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх, зам, тээврийн ослын улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох гэсэн үндсэн зарчмуудтай.” гэж тусгасан болно.</p>
3.	<p>Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 7.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах. Тус заалтын “маягтын дагуу бөглөж даатгагчид бичгээр эсхүл цахимаар хүргүүлнэ.” гэснийг “маягтын дагуу мэдээллийг даатгагчид бүрэн гүйцэд бичгээр эсхүл цахимаар хүргүүлнэ” гэж өөрчлөх саналтай байна. Учир нь практикт тухайн мэдүүлгийн маягыг ихэнх тохиолдолд бүрэн гүйцэд бөглөж өгдөггүй, уг заалт хэрэгжихэд хүндрэлтэй байх тул бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүргийг нь хуульд тусгай нь зүйтэй гэж үзэж байна.</p>	<p>Үгүй. Хуулийн төсөлд заавал тусгах шаардлагагүй, журмаар зохицуулагдах боломжтой гэж үзэв.</p>
4.	<p>Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлийг тодорхой болгох. Энэхүү зүйлд заасан даатгалын хураамж хэсэгт хураамжийн хэмжээ, илтгэлцүүрүүд огт тодорхойгүй байгааг тодорхой болгох.</p>	<p>Үгүй. Голлох итгэлцүүрүүд хуулийн төсөлд тусгагдсан байгаа ба итгэлцүүрүүд нь нэмэгдэх эсхүл хасагдах боломжтой байдлаар тусгасан. Хураамжийн хэмжээг гаднын улс орнуудын сайн туршлагын дагуу эрсдэлийн түвшин, эдийн засгийн суурь үзүүлэлттэй уялдсан актуар тооцоололд үндэслэн уян хатан байдлаар тогтоодог байх, өөрөөр хэлбэр хуульд даатгалын суурь хураамжийг хатуу заах нь учир дутагдалтай.</p>
5.	<p>Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах: ЖДТХ-ийн</p>	<p>Үгүй. “Заавал даатгалын холбооны саналыг харгалзан ...” гэж тодорхой тусгасан. Заавал</p>

	шинэчилсэн найруулгын 10.1-д хураамжийн хэмжээг Хороо тогтооно гэсэн боловч 10.2-т Заавал даатгалын холбооноос ирүүлсэн саналыг харгалзан батална гэсэн байна. Тус заалтын “Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооноос ирүүлсэн саналыг харгалзан” гэснийг “даатгалын холбогдох мэргэжлийн байгууллага, даатгагчдын саналыг харгалзан” гэж өөрчлөх саналтай байна. Энд хураамж тооцоолол хийх этгээд тодорхойгүй байгааг тодорхой болгох, мөн хураамж тооцоход даатгалын холбогдох мэргэжлийн байгууллага, даатгагчдаас санал авах шаардлагатай юм.	даатгалын холбоонд даатгалын компаниуд бүгд гишүүнчлэлтэй байх тул тэдгээрийн санал, мэргэжлийн актуар тооцоололд үндэслэсэн саналыг харгалзан үзэхээр байна.
6.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 15.1.2 дахь хэсэгт “цагдаагийн байгууллагад мэдэгдэх” үүргийг нэмэх.	Үгүй. Хуулийн төсөлд даатгалын тохиолдол гарсан даруйд энэ талаар даатгагчид мэдэгдэх, хэрэв даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд даатгагч болон цагдаагийн байгууллагад мэдэгдэхээр зохицуулав. Мөн хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд “ ... даатгалын тохиолдол гарсан үед цагдаагийн байгууллагын оролцоогүйгээр даатгалын нөхөн төлбөрийг шуурхай, чирэгдэлгүйгээр олгох талаарх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.” гэж тусгасан болно.
7.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 15.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах; Уг заалтын “цагдаагийн байгууллагад” гэснийг “цагдаагийн байгууллага, заавал даатгалын холбоонд” гэж өөрчлөх.	Үгүй. Хуулийн төсөлд заавал даатгалын сан нь зөвхөн баталгаат сангийн үүргийг гүйцэтгэх буюу дампуурсан даатгагчийн хохирогч нарын хохирлыг барагдуулах зорилготой. Харин хохирогчийн эрхийг хамгаалах нэгдсэн бүтэц нь даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй, даатгалгүй этгээдийн хохирлыг барагдуулахаар тусгасан болно.
8.	ЖДТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 15.4-т даатгалын шуурхай албанд дуудлага өгөх гэж оруулах.	Үгүй. Хуулийн төсөлд хохирогчийн эрхийг хамгаалах нэгдсэн бүтэц буюу Холбоо нь даатгалын шуурхай албаны үүргийг гүйцэтгэхээр тусгагдсан болно. Хуулийн төслийн 15.4 заалт нь шуурхай албаны

		дуудлага өгөхтэй холбоотой харилцааг зохицуулаагүй болно.
9.	Хуулийн төслийн 18.6.3 дахь заалт нь 18.6 дахь хэсэгт хамааралгүй байх тул тус заалтыг өөр хэсэгт оруулах шаардлагатай.	Тийм. Саналыг тусгаж 18.7 заалтад болгон өөрчлөв.
10.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 20.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах: Уг заалтын “ажлын 10 өдрийн дотор” гэснийг “ажлын 20 хоногийн дотор” гэж өөрчлөх саналтай байна. Эд хөрөнгөд учирсан хохирлыг ажлын 20 хоногт барагдуулахад боломжтой гэж үзэж байна. Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуульд эд хөрөнгөд учирсан хохирлыг 1 сарын дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно гэж байсныг ажлын 20 хоног гэж өөрчлөхөд тохиромжтой гэж үзэж байна.	Үгүй. Ихэнх нөхөн төлбөр шийдвэрлэлт нь уг хугацааны дотор байгаа бөгөөд хуулийн төсөлд даатгалын тохиолдлыг шалгах, баталгаажуулах процессыг цахим байдлаар хүргүүлэх боломжтой болсон.
11.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22.3 дахь хэсэгт өөрчлөлт оруулах: Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22.3 дахь хэсэгт “Холбооны үйл ажиллагааны болон нөхөн төлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг Холбооны гишүүн даатгагч нар бүрдүүлнэ” гэж заасан байх бөгөөд уг эх үүсвэр бүрдүүлэх хувь хэмжээ, зарцуулалтыг хуульчлан хязгаарлалт оруулах саналтай байна. Тухайлбал дээд хязгаар тавих хэрэгтэй. АЖДХ-ны жолоочийн даатгалын хураамжийн орлогоос жил бүр өндөр хувиар төвлөрүүлэлт авдаг, зарцуулалт тодорхойгүй, тайлагнаагүй байж дараа жилийнхийг нэг доор нэхэмжилж хүү алданги ярьдаг. Өндөр орлогоос өндөр хураамж тооцдог боловч ЖДС-н үр өгөөж огт байхгүй байна. Иймд даатгалын компаниудын ЖДС-д жилд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээний дээд хязгаарыг 30 сая төгрөг гэх мэтээр тодорхой хязгаартай журамлахын тулд хуульд хязгаартай байна гэж оруулахгүй бол Холбоо өөрийн дураар журмаа батлуулдаг.	Тийм. Саналыг тусгав.
12.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 15.5, 15.6 болон 21.1.2 дахь заалт хоорондоо зөрчилтэй байх тул уг зөрүүг арилгах.	Үгүй. Хуулийн төслийн 21.1.2 дахь заалтын дагуу даатгуулагч, жолооч нь 15.1, 15.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол даатгагч, Холбоо нь нөхөн төлж, эргээд буцаан нэхэмжлэх

		харилцааг зохицуулсан бөгөөд 15.5, 15,6 дахь заалтууд нь тухайн даатгуулагч, жолоочийн хүндэтгэх шалтгаангүйгээр үүргээ мэдэгдээгүй үеийн харилцааг зохицуулж байгаагаар ялгаатай болно.
13.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 21.1.3 дахь хэсгийг өөрчлөх: Уг заалтыг “даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас эсхүл жолоочоос” болгон өөрчлөх	Тийм. Хуулийн төслийн 21.1.3-т “даатгуулагч, жолооч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн этгээдээс;” гэж өөрчлөн найруулав.
14.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 21.1.4 дэх хэсгийг өөрчлөх: Уг заалтыг “даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас эсхүл жолоочоос” болгон өөрчлөх	Тийм. Хуулийн төслийн 21.1.4-т “даатгуулагч, жолооч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол тухайн этгээдээс;” гэж өөрчлөн найруулав.
15.	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 21.2 дахь хэсэгт нэмэлт оруулах: Уг хэсгийн 21.2.4 дэх хэсэгт “Даатгалгүй этгээд нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол буруутай этгээдээс” гэж нэмэлтээр оруулах	Тийм. Хуулийн төслийн 21.2.4-т “даатгуулагч, жолооч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол тухайн этгээдээс;” гэж өөрчлөн найруулав.
<b>III. Практикал даатгал ХК</b>		
1.	Жолоочийн даатгалын тухай хууль гэхээсээ илүүтэйгээр Заавал даатгалын тухай хууль гэж баталсан бол илүү үр өгөөжтэй байхаар байна. Учир нь Даатгалын тухай хуулийн төсөлд Даатгалыг сайн дурын болон Заавал даатгал гэж ангилахаар заажээ. Иймд Заавал даатгалын тухай Ерөнхий хуулийг баталж, заавал даатгалын төрлүүдийг тодорхой зааж, үндсэн нөхцөл шаардлагыг тодорхойлон, тухайн даатгалын төрөл бүрд хамаарах нарийвчилсан харилцааг эрх бүхий байгууллагын журмаар зохицуулахаар шийдэх саналтай. Жишээ нь: Заавал даатгалын төрөл, жолоочийн даатгал, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал, тэсрэх, тэсэлгээний бодис үйлдвэрлэгчийн хариуцлагын даатгал г.м заагаад энэ төрөл бүрээ нарийвчилсан журмаар зохицуулдаг байх.	Тийм. Хуулийн төслийн 7.2-т “Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна.” гэж тусгасан.

2.	Хуулийн төсөлтэй танилцахад албан журмын даатгалын үйл ажиллагаанд тавих Хорооны хяналт хэт их, хэтэрхий их журам батлахаар байгаа тул хуульд өөрт нь шууд заах боломжтой зохицуулалтуудыг тодорхой заах саналтай байна. 12 тооны журам гаргаж болохоор байна.	Хэсэгчлэн тусгав. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Даатгалын тухай хуульд заасан 14.2-т заасан даатгалын багц дүрмийн тоог 22-16 болгон бууруулж шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Мөн Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс Хорооны батлан гаргахаар тусгасан зарим заалтыг хасав. Тухайлбал: “Шуурхай албаны ажиллах журам, бүтэц, бүрэлдэхүүнийг Албан журмын даатгагчдын холбооны саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо батална.”, “Хороо жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзахтай холбоотой журмыг батална.” зэрэг заалтууд хасагдсан болно.”, “Хороо жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзахтай холбоотой журмыг батална.”, “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.” зэрэг журмууд хасагдсан болно.
3.	Хуулийн төслийн 3.1.9 дэх заалтыг хасах саналтай. Учир нь: Заавал даатгалын сангаас гэрээний хугацаа дууссан, даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй зэрэг тохиолдолд нөхөн төлбөр олгох ёстой. Энэ үүргээ өнөөдрийг хүртэл АЖДХ нь хангалтгүй гүйцэтгэж ирсэн тул энэ сангаас нөхөн төлбөр авах нөхцөлийг тодорхой болгох шаардлагатай. Даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгох үүрэг хүлээж байгаа Даатгагч нь хохирогчийн эрх ашгийг хамгаалах холбоог байгуулж, гишүүнчлэлтэй байх нь зохимжгүй байна.	Үгүй. Хуулийн төсөлд заавал даатгалын сан нь зөвхөн баталгаат сангийн үүргийг гүйцэтгэх буюу дампуурсан даатгагчийн хохирогч нарын хохирлыг барагдуулах зорилготой. Харин хохирогчийн эрхийг хамгаалах нэгдсэн бүтэц нь даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй, даатгалгүй этгээдийн хохирлыг барагдуулахаар тусгасан болно.
4.	Хуулийн төслийн 7.4 дэх заалтад дараах өөрчлөлт оруулах: Даатгалын мэдүүлгийн болон гэрээний загварыг Санхүүгийн Зохицуулах Хороо батална. Энэ нь Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 1-т “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг	Үгүй. Хуулийн төсөл дах даатгалын мэдүүлгийн болон гэрээний загвар нь хуулийн дагуу хэрэгжүүлж буй даатгуулагч бүрд ижил

	чөлөөтэй байгуулах, түүнийг агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй” гэж заасантай зөрчилдөж байна. Иймд СЗХ-ноос гэрээний загварыг батлах биш гэрээний үндсэн стандарт нөхцөлүүдийг баталж, даатгагч, даатгуулагч нар бусад нөхцөлөө харилцан тохиролцох боломжтой байх байдлаар өөрчлөх саналтай.	стандарт нөхцөлтэй гэрээний харилцааг зохицуулах тул Хороо батлахаар тусгав.
5.	Хуулийн төслийн 7.3 “Даатгалын гэрээг энэ хуулийн 7.4-т заасан загварын дагуу байгуулж, хуульд заасан хэлбэрээр баталгаажуулсан байна.” Хуульд заасан хэлбэр гэдэг нь яг ямар хэлбэрээр байгуулахыг зөвшөөрч байгаа нь тодорхойгүй. Тодруулж хэлбэл хуулийн төсөлд цахим үйл ажиллагааг дэмжиж байгаа юм шиг хэр нь даатгалын гэрээг цахимаар байгуулж болох талаар тодорхой заагаагүй байна. Ийм учраас хуулийн төслийн 7.3-т заасан хуульд заасан хэлбэр гэдгийг Иргэний хуулийн 431.3-т заасан “даатгалын гэрээг бичгээр байгуулна” гэсэн энэ шаардлага гэж ойлгохоор байна. Хэрэв тийм бол Хуулийн төслийн 7.3-т даатгалын гэрээг бичгээр болон цахимаар байгуулж болно гэж заах саналтай.	Хэсэгчлэн тусгав. Даатгалын гэрээний харилцаа нь Иргэний хуулийн 43-р бүлэгт зааснаар нарийвчлан зохицуулагддаг бөгөөд Иргэний хуульд дагалдах хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж бичгээр болон цахимаар гэрээ байгуулах боломжтой байхаар тусгав. Харин уг хуулийн төсөлд Иргэний хуульд заасан хэлбэрээр буюу гэрээг бичгээр болон цахим хэлбэрээр байгуулж болох тухай тусгав.
6.	Хуулийн төслийн 9.1-т “даатгалын үнэлгээний доод хэмжээ” гэдгийг “даатгалын үнэлгээний 1 жилд олгох доод хэмжээ” гэж өөрчлөх, өөрөөр хэлбэл тус заалтыг “Жолоочийн даатгалын үнэлгээний 1 жилд олгох доод хэмжээ дараах хэмжээтэй байна” гэж өөрчлөх саналтай. Мөн “Даатгалын үнэлгээ нь энэ хуулийн 9.1-д заасан үнэлгээнээс өндөр байхаар даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож болох бөгөөд энэ тохиолдолд даатгалын хураамжийн хэмжээг даатгалын гэрээнд заасны дагуу энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.” гэсэн энэ заалтыг нэмэх саналтай.	Үгүй. “Жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь ...” гэж зааж тусгасан болно. Даатгалын үнэлгээний 1 жилд олгох доод хэмжээ гэж оруулбал даатгуулагч бүр жил бүр үнэлгээний хэмжээгээр нөхөн төлбөр авахаар ойлгогдохоор байна. Даатгалын үнэлгээ гэдэг ойлголт нь өөрөө даатгуулагчийн гэрээний хугацаанд буюу 1 жилийн хугацаанд авч болох нөхөн төлбөрийн дээд хэмжээ билээ.
7.	Хуулийн төслийн 11.2-т тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах журмыг Хороо батална гэснийг өөрчилж, олгох болон олгохоос татгалзах нөхцөлийг хуульд шууд заах саналтай байна.	Тийм. Саналыг тусгаж журмыг хасав.
8.	Хуулийн төслийн 14.1 дэх хэсэгт дараах заалтыг нэмэх саналтай. Үүнд: 14.1.7 Даатгуулагч даатгалын тохиолдлыг	Үгүй. Даатгуулагч үүргээ биелүүлээгүй нь шууд нөхөн төлбөр олгохгүй байх үндэслэл болохгүй

	газар дээр нь зураг, дүрс бичлэгээр баталгаажуулаагүй тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй.	бөгөөд Даатгалын тухай хуулийн 8.5 заалтын дагуу зохицуулсан байдаг.
9.	Хуулийн төслийн 13.3. Даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолоочийг даатгагчид хуваарилах журмыг Хороо батална гэсэн энэ заалтыг хүлээн зөвшөөрөхгүй, өөрөөр зохицуулах саналтай байна. /Жишээ нь Заавал даатгалын холбооны сангаас гаргах гм./	Үгүй. Хуулийн төслийн зарчмуудад “жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагч нь жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулах хүсэлтээс татгалзахгүй байх” гэсэн заалтыг нэмж тусгасан бөгөөд Заавал даатгалын холбоо нь заавал даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч дампуурсан үед түүний хохирогчдод гэрээний хугацаанд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилготой байхаар зохицуулсан.
10.	Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг хасах саналтай. Заавал даатгалын сангаас тус тохиолдлуудад нөхөн төлбөр олгох ёстой, энэ талаарх зохицуулалтуудыг нэмж оруулах саналтай.	Үгүй. Хуулийн төсөлд заавал даатгалын сан нь зөвхөн баталгаат сангийн үүргийг гүйцэтгэх буюу дампуурсан даатгагчийн хохирогч нарын хохирлыг барагдуулах зорилготой бөгөөд олон улсын жишгийг харахад мөн баталгаат сангуудын үйл ажиллагаа үүнд чиглэдэг байна. Харин хохирогчийн эрхийг хамгаалах нэгдсэн бүтэц нь даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй болон даатгалгүй этгээдийн хохирлыг барагдуулахаар тусгасан болно.
<b>IV. Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо</b>		
1.	Төслийн 7.6-д 24 цагт гэснийг өөрчлөх, Даатгалын гэрээ хураамж төлөгдсөнөөр хүчин төгөлдөр болно.	Үгүй. Даатгалын тохиолдол бий болсон даруйд даатгуулж даатгалын нөхөн төлбөр авах боломжтой болдог байдлыг хориглон, маргааш өдрөөс нь даатгал нь хүчинтэй үйлчилдэг байх зохицуулалт олон улсад түгээмэл байдаг бөгөөд даатгалын залилан, маргааныг шийдвэрлэх гол зохицуулалт юм.
2.	Төслийн 15.6-г хасах /15.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол хохирлыг жолооч өөрөө хариуцах тухай/	Үгүй. Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн гол зорилго нь зам тээврийн ослын үед хохирогчийн эрхийг хамгаалах билээ. Даатгалгүй этгээд 15.2-т заасан үүргээ биелүүлээгүй нь хохирогчид нөхөн төлбөр олгохгүй байх үндэслэл болох ёсгүй бөгөөд



		харин хүндэтгэх шалтгаангүйгээр уг үүргээ биелүүлээгүй бол тухайн жолооч хохирлыг өөрөө хариуцахаар зохицуулав.
3.	18.5 даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол гэснийг хасах	Үгүй. Жолоочийн даатгалын гэрээний загварыг Хороо батлах бөгөөд даатгалын байгууллагуудын саналд үндэслэн хамтран батлах тул хасах шаардлагагүй гэж үзэв.
4.	4.1.5-ыг хасах /зардлын тухай/	Үгүй. Тус даатгалын бүтээгдэхүүн нь аливаа даатгалын байгууллагын хувьд ашгийн бус байдаг билээ.
5.	5.3.Монгол улсын хилээр дамжин өнгөрөх болон түр хугацаанд нэвтэрч, зам тээврийн хөдөлгөөнд оролцож буй авто тээврийн хэрэгслийн өмчлөгч гэж нэмэх	Тийм. Саналыг тусгав.
6.	9.1 жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь доор дурдсан хэмжээтэй байх ба нэг удаагийн тохиолдолд доор дурдсан үнэлгээний дээд хязгаарт багтаан хохирлын нөхөн төлбөр төлнө гэх	Үгүй. Хуулийн төслийн 9.1-д “жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь даатгалын тохиолдол бүрд ...” гэж тусгасан нь зөвхөн 1 удаагийн тохиолдолд олгоод даатгалын хамгаалалт зогсох бус, даатгалын тохиолдол бүрд үнэлгээний хязгаарт багтаан олгогддог зарчимтай.
7.	9.1.4 Энэ хуулийн дагуу жолоочийн даатгалаар нөхөн төлбөр төлсөн дүнгээр даатгалын үнэлгээг хасагдуулах бөгөөд даатгуулагч нь нөхөн төлбөр авсан тухай бүр зохих хураамж төлж 9.1 дүгээрт заасан доод хэмжээгээр даатгалын үнэлгээг сэргээнэ.	Үгүй. Жолоочийн даатгалын үнэлгээ бусад сайн дурын даатгал шиг үнэлгээ буурах бус, хохирогчийн эрх ашгийг хамгаалсан даатгал учир үнэлгээг сэргээх боломжгүй юм.
8.	Энэ хуулийн 5.3-т заасан этгээдийн заавал даатгуулах хуулийн хэрэгжилтэд Хил хамгаалах газар эсвэл хилийн бүс дэх Авто тээврийн хяналт хэрэгжилтэд хяналт тавина. Үүнтэй уялдан Хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	Хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 13.4-т “... энэ хуулийн 5.3-т заасан этгээдийн заавал даатгуулах хуулийн хэрэгжилтэд хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавина.” гэж тусгав. Харин Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар бус холбогдох Хорооны журмаар зохицуулахаар тусгав.
9.	6.4.Даатгалын нөхөн төлбөр авснаас даатгалын үнэлгээ буурч хохирлын нөхөн төлбөр төлөхөд хүрэлцэхгүй болсон хэсэг	Үгүй. Жолоочийн даатгалын үнэлгээ бусад сайн дурын даатгал шиг үнэлгээ буурах бус, харин хохирогчийн эрх ашгийг хамгаалсан даатгал

		учир үнэлгээг сэргээх боломжгүй байдаг зарчимтай билээ.
10.	21.1.5 Даатгалгүй этгээд даатгалтай тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан бол даатгагч нь Холбооны заавал даатгалын баталгаат сангаас	Үгүй. Хуулийн төслийн 21.2-т даатгалгүй этгээд болон даатгалын тохиолдол гаргаад зугтаасан жолоочийн хохирлын нөхөн төлбөрийг жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дурдсан Холбоо нь буцаан нэхэмжлэх талаар зохицуулсан бөгөөд харин даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан заавал даатгалын сан нь даатгагч дампуурсан тохиолдолд хохирогчид нөхөн төлбөрийг олгоод тухайн даатгалгүй этгээдээс буцаан нэхэмжлэхээр зохицуулсан.
11.	23.7 Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын зуучлагч нь Холбоонд сайн дурын гишүүнчлэлтэй байж болно.	Үгүй. Хуулийн төслийн 23-р зүйл буюу “Холбооны бүтэц, зохион байгуулалт” гэсэн зүйлийг бүхэлд нь хассан бөгөөд уг харилцааг энэхүү хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үзсэн болно.
12.	Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг тодорхой болгох	Үгүй. Хуулийн төслийн аль заалтад хамаарах нь тодорхойгүй бөгөөд жолоочийн даатгалын болон бусад даатгалтай холбогдох хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулалт хийх нь Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг болох тухай Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан байдаг.
13.	9.1.1 хохирогчийн амь нас эрүүл мэндийн хувьд нэг хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг,	Тийм. Саналыг тусгасан байсан.
14.	9.1.2 хохирогчийн амь нас эрүүл мэндийн хувьд нэгээс дээш хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг	Тийм. Саналыг тусгасан байсан.
15.	9.1.3 хөрөнгийн хувьд нэг хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг	Тийм. Саналыг тусгасан байсан.

16.	10.2 Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо даатгалын суурь хураамжийн хэмжээг итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцох бөгөөд Даатгалын хураамж тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооноос ирүүлсэн саналыг харгалзан Хороо батална гэх	Тийм. Саналыг тусгасан байсан.
17.	13.6 Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа автотээврийн хэрэгслийг хилийн бүсэд жолоочийн даатгалд хамруулах журмыг Хороо батална	Тийм. Уг харилцааг журмаар зохицуулах шаардлагагүй тул заалтыг төслөөс хасав.
18.	Монгол улсын хилийн тухай хуулийн 17.1-д түүний гэсний дараа “жолоочийн заавал даатгал” гэж нэмэх	Үгүй. Уг хуулийн 17.1 заалт нь холбогдолгүй байгаа бөгөөд хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиудад дурдагдаагүй болно.
<b>V. Монголын Даатгалын Холбоо</b>		
1.	1.1. “Хамгаалах,” гэсний дараа жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэхтэй” гэж нэмэх	Үгүй. Жолоочийн хураамжийн хэмжээг тооцох аргачлал нь бонус-малус систем буюу хариуцлагагүй жолоочийн хураамжийн хэмжээ нэмэгддэг, энэ нь нэг төрлийн жолоочийг хариуцлагажуулах арга хэрэгсэл юм. Харин жолоочийг хариуцлагажуулах үндсэн гол үүрэг нь даатгалын салбарын бус, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад зам, тээврийн салбарт хамаарах тул хуулийн төслийн зорилгод жолоочийг хариуцлагажуулах гэж тусгах нь даатгалын зарчимд нийцэхгүй.
2.	3.1.7 дээр жолоочийн даатгалын сан гэснийг хассан	Тийм. Хуулийн төсөлд 3.1.7 заалтаас хассан.
3.	3.1.10 дээр учирсан гэсний дараа “даатгуулагчаас бусад” гэж нэмсэн	Үгүй. Хуулийн төслийн уг заалт хасагдсан учир нэмэх шаардлагагүй билээ.
4.	4.1.1 өмчлөгч гэснийг жолооч гэж өөрчлөх	Үгүй. Хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд “Хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах атал зарчим нь тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах гэж заасан нь зам тээврийн ослын

		улмаас үүдэх эрсдэл, бусдын өмнө хүлээх хариуцлагыг яг аль субъектэд хүлээлгэх үндсэн зорилго нь ойлгомжгүй, улмаар даатгалын хураамж, итгэлцүүр тооцоход хүндрэл үүсгэдэг;" талаар дурдсан бөгөөд уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн гол зарчмын өөрчлөлтүүдийн нэг нь юм.
5.	4.1.5 Даатгалын гэрээ байгуулах, даатгалын тохиолдлыг бүртгүүлэх, шалгах, шийдвэрлэх, нөхөн төлбөрийг хохирогчид олгох ажиллагааг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх" гэж нэмэх	Хэсэгчлэн тусгав. Даатгалын гэрээ байгуулах харилцааг уг хуулийн төслийг дагалдан батлагдах Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тусгахаар зохицуулав. Мөн цахим хэлбэрээр нөхөн төлбөр шийдвэрлэх ажиллагааг хуулийн төслийн 9.4-т "Даатгалын нөхөн төлбөрийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлсэн дараах баримтыг үндэслэн олгоно." гэж тусгасан болно.
6.	5.1 ба 5.2 өмчлөгч гэснийг жолооч гэж өөрчлөх	Үгүй. Мөн хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд "Тус хуулийн зорилт нь ... хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог бөгөөд тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах, хохирогчид нөхөн төлбөр олгох, жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх, зам, тээврийн ослын улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох гэсэн үндсэн зарчмуудтай." гэж тусгасан болно.
7.	7.1 жолооч нь гэсний дараа "зам тээврийн ослын улмаас" гэж нэмэх, мөн хариуцлагын, бичгээр эсхүл цахимаар гэж нэмэх	Тийм. Саналыг тусгаж хуулийн төслийн 1.1 болон 7.1 заалтуудад зам тээврийн осол болон авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас учирсан хохирлыг төлөхөөр зохицуулав. Мөн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цахим хэлбэрээр даатгалын гэрээ байгуулах боломжтой байхаар зохицуулав.

8.	7.2 Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан хариуцлагын даатгалын гэрээг байгуулахын өмнө гэж нэмэх, мөн бичгээр эсхүл цахимаар гэх	Тийм. Саналыг тусгав.
9.	7.3-г хасах	Үгүй. Энэхүү заалтын дагуу даатгалын гэрээг энэ хуулийн 7.4-т заасан загварын дагуу байгуулж, хуульд заасан хэлбэрээр баталгаажуулсан байх шаардлагатай билээ.
10.	7.5-д Улсын хилээр түр болон дамжин өнгөрөх автотээврийн хэрэгслээс бусад тохиолдолд	Тийм. Хуулийн төслийн 5.3-т "... тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч энэ хуулийн 6.1-д зааснаас бусад тохиолдолд заавал даатгуулна." гэж өөрчлөн найруулав.
11.	9.1 даатгалын тохиолдол бүрд гэснийг хасах	Үгүй. Жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь даатгалын тохиолдол бүрд ... гэж тусгасан нь зөвхөн 1 удаагийн тохиолдолд олгоод даатгалын хамгаалалт зогсох бус, даатгалын тохиолдол бүрд үнэлгээний хязгаарт багтаан олгогддог зарчимтай.
12.	"А", "В" болон "Механизм" ангиллын тээврийн хэрэгслийн хувьд нэг хохирогчтой бол эд хөрөнгийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 16 дахин хүртэл, амь нас, эрүүл мэндийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 дахин хүртэл, нэгээс дээш хохирогчтой бол нийт хохирлын үнэлгээнд эзлэх хувиар тооцож хуваах бөгөөд эд хөрөнгийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 дахин хүртэл, амь нас эрүүл мэндийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 64 дахин хүртэл;"	Үгүй. Хуулийн төслийн 10.1-д даатгалын үнэлгээнд ногдох даатгалын суурь хураамжийн хэмжээг Хороо автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааруулан тогтоохоор тусгасан. Өөрөөр хэлбэр автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааран даатгалын суурь хураамж нь ялгаатай байхаас үнэлгээ буюу нөхөн төлбөрийн хэмжээ нь үл хамаарахаар зохицуулалттай байхаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдан батлагдсан болно.
13.	"С" болон "D" ангиллын тээврийн хэрэгслийн хувьд нэг хохирогчтой бол эд хөрөнгийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 дахин хүртэл, амь нас, эрүүл мэндийн хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 64 дахин хүртэл, нэгээс дээш хохирогчтой бол нийт хохирлын үнэлгээнд эзлэх хувиар тооцож хуваана.	Үгүй. Хуулийн төслийн 10.1-д даатгалын үнэлгээнд ногдох даатгалын суурь хураамжийн хэмжээг Хороо автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааруулан тогтоохоор тусгасан. Өөрөөр хэлбэр автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааран даатгалын суурь хураамж нь ялгаатай байхаас үнэлгээ буюу нөхөн төлбөрийн хэмжээ нь үл хамаарахаар

		зохицуулалттай байхаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдан батлагдсан болно.
14.	“Даатгалын үнэлгээ нь энэ хуулийн 9.1-д заасан үнэлгээнээс өндөр байхаар даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож болох бөгөөд энэ тохиолдолд даатгалын хураамжийн хэмжээг даатгалын гэрээнд заасны дагуу энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.” гэсэн заалтын харилцан гэсний дараа “тохиролцсон бол тус давсан хэсэгт хураамжийн хэмжээг харилцан тохиролцож тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд даатгалын хураамжийн хэмжээг даатгалын гэрээгээр энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.” гэж өөрчлөх	Үгүй. Уг шинэчилсэн найруулгын төсөлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 9.2 заалтыг хассан бөгөөд уг хуулийн төсөл нь жолоочийн хариуцлагын даатгалын заавал даатгуулах харилцааг л зохицуулахаар тусгасан.
15.	9.3. Даатгуулагч нь гэрээний хугацаанд нөхөн төлбөр авсан бол нэмэлт хураамж төлснөөр даатгалын үнэлгээний хэмжээг сэргээж болно. гэх	Үгүй. Хуулийн төслийн 9.1-д “жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь даатгалын тохиолдол бүрд ...” гэж тусгасан нь зөвхөн 1 удаагийн тохиолдолд олгоод даатгалын хамгаалалт зогсох бус, даатгалын тохиолдол бүрд үнэлгээний хязгаарт багтаан олгогддог зарчимтай. Мөн жолоочийн хариуцлагын даатгалын олон улсын туршлагыг судлан үзэхэд албан журмын даатгалын хамгаалалтыг сэргээхтэй холбоотой зохицуулалт байхгүй байна.
16.	10.1.Даатгалын суурь хураамжийн хэмжээ, түүнийг нэмэгдүүлэх буюу хорогдуулах итгэлцүүрийг санхүүгийн зохицуулах хороо нь мэргэжлийн хөндлөнгийн байгууллагын зөвлөмжид (Актуарчийн нийгэмлэг гэх мэт) үндэслэн шинэчлэн тогтооно, мэргэжлийн байгууллагын холбоодын төлөөлөл бүхий байнгын бус ажлын хэсэг 2 жил тутам шинэчлэх эсэх тухай хэлэлцэж дүгнэлт гаргана гэх	Үгүй. “Заавал даатгалын холбооны саналыг харгалзан ...” гэж тодорхой тусгасан. Заавал даатгалын холбоонд даатгалын компаниуд бүгд гишүүнчлэлтэй байх тул тэдгээрийн санал, мэргэжлийн актуар тооцоололд үндэслэсэн саналыг харгалзан үзэхээр байна.
17.	10.2.Зөвлөмжид үндэслэн ажлын 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны хурлаар суурь хураамж болон итгэлцүүрийг батална гэх.	Үгүй. Хуулийн төслийн 9-р зүйлд суурь хураамжийн хэмжээг Хороо тогтоохыг, харин 10-р зүйлд Хорооны итгэлцүүр хэрэглэх журмыг нь батлах тухай тусган зохицуулав.
18.	10.3.Даатгалын суурь хураамжийн хэмжээ, түүнийг нэмэгдүүлэх буюу хорогдуулах итгэлцүүрийг тодорхойлох	Үгүй. Хуулийн төсөлд итгэлцүүрийг тодорхойлох ажлын хэсгийн ажиллах журмыг хуульд тусгах шаардлагагүй болно.

	ажлын хэсгийн ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос батална гэх.	
19.	“даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол,” гэсэн заалтад даатгуулагч, түүний өмчлөлийн болон эзэмшлийн эд хөрөнгөд учирсан хохирол; гэж нэмэх	Тийм. Хуулийн төслийн 14.1.3-т “даатгуулагчийн болон жолоочийн өөрийн автотээврийн хэрэгсэл, ачаа, хөрөнгө, эрүүл мэндэд учирсан хохирол;” гэж тусган найруулав.
20.	Даатгалын тохиолдолд үл хамаарах хохирол гэсэн зүйлд хохирлын хэмжээг тогтооход гарсан зардал; гэж нэмэх	Үгүй. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5-д “Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцна.” гэж байгаа бөгөөд уг заалт шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр тусгагдаж байгаа.
21.	“даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын баталгааг шалгуулах;” заалтад даатгагчид гэсний дараа “хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд” гэж нэмэх	Тийм. Хуулийн төслийн 15.1.3-т “даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд даатгагч болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх;” гэж тусгав.
22.	“даатгагч нь дампуурсан бол шуурхай албанд болон шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх.” заалтыг хасах	Тийм. Саналыг тусгаж хасав.
23.	13.4. Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд даатгагчаас хохирогчтой тохиролцож болох бөгөөд даатгагчийн зөвшөөрөлгүйгээр даатгуулагч нь хохирогчтой учирсан хохирлыг барагдуулахаар харилцан тохиролцож болохгүй. гэх	Тийм. Хуулийн төслийн 15.4-т “... даатгагчид энэ тухайгаа мэдэгдэж, түүний зөвшөөрлийн дагуу хохирлыг эргэн төлүүлэхээр жолооч барагдуулж болно.” гэж найруулан тусгав.
24.	15.4. Даатгагч нь цагдаагийн байгууллагаас даатгалын тохиолдолтой холбоотой дүрс бичлэг, зам тээврийн ослын бүртгэлийг гаргуулж авах эрхтэй. гэж нэмэх	Тийм. Хуулийн төслийн 17.5-д “Даатгагч нь цагдаагийн байгууллагаас даатгалын тохиолдолтой холбоотой дүрс бичлэг, зам тээврийн ослын бүртгэлийг гаргуулж авах эрхтэй.” гэж тусгав.
25.	15.5. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 24.2-т заасан мэдээллийг даатгалын тохиолдлыг	Тийм. Хуулийн төслийн 17.6-д “Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 23.2-т заасан мэдээллийг даатгалын

	шийдвэрлэсэн тухай бүр Жолоочийн даатгалын мэдээллийн санд хүргүүлэх үүрэгтэй. гэж нэмэх	тохиолдлыг шийдвэрлэсэн тухай бүр Жолоочийн даатгалын мэдээллийн санд хүргүүлэх үүрэгтэй.” гэж тусгав.
26.	16.3. Даатгагч эсхүл даатгуулагч нь хохирлын үнэлгээний талаар харилцан тохиролцоогүй бол даатгалын хохирол үнэлэгч томилон даатгалын тохиолдлыг шалгуулах хохирлын хэмжээг тогтоолгох зорилгоор тухайн автотээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийлгэж болно. гэх	Үгүй. Даатгагч болон даатгуулагч нар нь хохирлын үнэлгээний талаар харилцан тохиролцохоос өмнө тухайн автотээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийж болох тухай хуулийн төслийн 18.2-т зааж тусгав.
27.	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн “Дараах үндэслэлийн аль нэг нь байвал жолоочийн даатгалын сан хохирогчийн өргөдлийг үндэслэн түүнд нөхөн төлбөр олгоно:” гэсэн заалтын сан гэсний дараа “Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасан баримтыг” гэж нэмэх	Үгүй. Жолоочийн даатгалын сангаас олгох даатгалгүй этгээдийн учруулсан болон даатгалын тохиолдол гаргаад зугтаасан жолоочийн учруулсан хохирлыг Холбоо нөхөн төлөх, харин даатгагч дампуурсан тохиолдолд даатгуулагчийн хохирлыг даатгалын тухай хуулийн төсөлд тусгагдсан Заавал даатгалын холбоо нөхөн төлөхөөр зохицуулсан бөгөөд аль аль тохиолдолд нөхөн төлбөрийг олгоход Даатгалын тухай хуулийн 8.4-т заасан (шинэчилсэн найруулгын төслийн 9.4) баримтыг үндэслэн олгох боломжгүй юм.
28.	18.1.5. Даатгуулагч нь даатгалын тохиолдол гарсан талаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй. гэж нэмэх	Үгүй. Холбогдох зохицуулалтыг өөр зарчмаар шинэчилсэн өөрөөр хэлбэл эдгээр тохиолдлуудад жолоочийн сангаас нөхөн төлбөр олгодог зохицуулалтыг өөрчилсөн.
29.	18.1.6. даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан гэж нэмэх	Үгүй. Холбогдох зохицуулалтыг өөр зарчмаар шинэчилсэн өөрөөр хэлбэл эдгээр тохиолдлуудад жолоочийн сангаас нөхөн төлбөр олгодог зохицуулалтыг өөрчилсөн.
30.	19.1.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь нөхөн төлбөрийн хэмжээг дараах байдлаар тогтооно. 19.1.1. Хүний амь нас хохирсон бол даатгалын үнэлгээний дүнгээр; 19.1.2. Эрүүл мэндэд хохирол учирсан хохирлыг даатгалын үнэлгээний хязгаарт багтаан эмчилгээний зардлаар; 19.1.3. Эд хөрөнгөнд учирсан хохирлын хэмжээг хохирогчтой тохиролцсон хэмжээгээр даатгагчаас олгох бөгөөд ийнхүү	Үгүй. Адил агуулга бүхий заалт хуулийн төсөлд тусгагдсан



	тохиролцоод хүрээгүй тохиолдолд хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт, энэ хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтооно. /19.1-ийг өөрчилсөн/	
31.	19.2-т засварлуулахаар гэж нэмэх	Үгүй. Адил агуулга бүхий заалт хуулийн төсөлд тусгагдсан
32.	19.4 дээр хойш гэсний дараа “14 хоногийн дотор” гэх	Үгүй. Адил агуулга бүхий заалт хуулийн төсөлд тусгагдсан
33.	20.1.2-20.1.3-хасах	Үгүй. 20.1.2-20.1.3 гэсэн заалтууд байхгүй болно.
34.	20.2.5. даатгалын тохиолдол гарсан талаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос; гэх	Үгүй. Адил агуулга бүхий заалт хуулийн төсөлд тусгагдсан
35.	20.3.Энэ хуулийн 20.2-т заасан буруутай этгээд нас барсан эсвэл төлбөрийн чадваргүй болох нь шүүхээр тогтоогдсон бол Жолоочийн даатгалын сангийн нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрх дуусгавар болно. гэх	Үгүй. Жолоочийн даатгалын сантай холбоотой зохицуулалтыг тус хуулийн төслөөс хассан
36.	21.2 Даатгалын мэргэжлийн холбоо нь гэх	Үгүй. Заавал даатгалын холбоо гэж Даатгалын тухай хуулийн төсөлд шинэчлэн найруулсан
37.	22.1.7. жолоочийн даатгалын санд төвлөрсөн хөрөнгийн хадгаламжийн хүүгийн орлого гэж нэмэх	Үгүй. Даатгалын тухай хуульд хамаарна
38.	23.1.5.даатгалын тохиолдлыг мэдэгдэх, баримтжуулах, шалган шийдвэрлэхтэй холбоотой нийтлэг үйл ажиллагааг санхүүжүүлэх. гэж нэмэх	Үгүй. Даатгалын тухай хуульд хамаарна
39.	23.3.Энэ хуулийн 23.1.2-23.1.5-т заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд жолоочийн даатгалын сангаас зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг Мэргэжлийн холбооны саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо тогтооно. гэх	Үгүй. Даатгалын тухай хуульд хамаарна
40.	24.2-т даатгуулагчийн мэдүүлэг, хохирлын үнэлгээ, зам тээврийн осол, тээврийн хэрэгслийн засварын түүх, зөрчлийн тухай, гэснийг хасах	Үгүй. Даатгалын тухай хуульд хамаарна
41.	24.4 Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Мэргэжлийн гэх	Үгүй. Даатгалын тухай хуульд хамаарна
42.	24.6 хэмжээг гэсний дараа Мэргэжлийн холбооны гэх, үндэслэн гэсний дараа Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоох гэх,	Үгүй. Адил агуулга бүхий заалт хуулийн төсөлд тусгагдсан

43.	25 дугаар бүлэг хасах	Үгүй. Хуулийн төсөлд тусгагдсан байсан
44.	27.1-д 82 гэснийг 92 гэх	Үгүй. Даатгалын тухай хуульд заасны дагуу гомдол, маргаан шийдвэрлэхээр хуулийн төсөлд тусгасан

---oOO---